

Эмгэг судлалын үндэсний төвийн засварыг хийж гүйцэтгэх аж ахуйн нэгжийг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Захиалагч: Эмгэг судлалын үндэсний төв

Үйлчилгээний нэр: Төвийн барилга байгууламжийн засвар, үйлчилгээ

Хийж гүйцэтгэх ажлууд:

1. 82 м2 бүхий 3 өрөөний иж бүрэн өрөөний хана, тааз, шалыг шинэчилж засахдаа Барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2023.06.26-ны өдрийн 150/A/271/A/225 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Боловсролын болон эрүүл мэндийн барилга байгууламжийн засварт эрүүл ахуйн чанар, стандартын шаардлага хангасан тосон болон усан суурьтай будаг ашиглах, түүнд хяналт тавих, хүлээж авах үйл ажиллагааны журам”-ыг баримтална.
2. Явган хүний орц, гарцыг автомашины зогсоолын хэсгээс тусгаарлах 8 ширхэг шон(bollard) байрлуулж шонгуудыг хооронд нь гинжээр холбон суурилуулах.

Үзүүлэлт	Хэмжээ/Зөвлөмж
Өндөр (газраас дээш)	0.8–1.0 м
Диаметр	100–200 мм
Шон хоорондын зай	1.2–1.5 м (явган хүн чөлөөтэй гарах, авто машин нэвтрэхгүй байхаар).
Суурилуулах гүн	300–600 мм (газар дор бэхэлгээтэй)
Материал	Металл (ган, ширэм), бетон, полимер бүрхүүлтэй ган гэх мэт
Тэмдэглэгээ	Шөнийн үед харагдах тууз, гэрэлтүүлэгтэй байж болно

Санхүүжилтийн эх үүсвэр: Байгууллагын 2026 оны төсвийн хүрээнд

Гүйцэтгэх хугацаа: 10-20 хоног

Үнэлгээний арга: Харьцуулах үнэ

Үнийн санал ирүүлэх хугацаа, хаяг: Үнийн саналын хугацаа: 2026 оны 03-р сарын 24-ны өдрийн 16:00 цаг хүртэл

Санал хүлээн авах цахим хаяг: emgegsudlal@gmail.com

Холбоо барих утас: 11-311733